



# “ОЮУНЛАГ ДАРХАН-II”

ДЭД ХӨТӨЛБӨР



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 61 дүгээр тогтоолоор “Оюунлаг Дарханчууд-II” дэд хөтөлбөрийг 5 зорилт, 35 арга хэмжээг хэрэгжүүлж байна.

## **ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:**

Иргэдийн дунд шинжлэх ухаанч үзэл санааг бүтээлчээр хөгжүүлж, хүнлэг энэрэнгүй ёс суртахуунтай, үндэсний хэл бичгийн мэдлэг, чадвар, тасралтгүй бүтээлчээр суралцдаг **“Оюунлаг Дархан”**-ы иргэдийг төлөвшүүлж хөгжүүлнэ.

## **ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:**

- Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: АЗДТГ, НБХ, БШУГ
- Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: СӨББ, ЕБС, СУГ, ИДМСК, БТСГ

## САНХҮҮЖИЛТ:

- Улс, орон нутгийн төсөв
- Олон улсын байгууллагын тусламж, хандив, төсөл
- Төрийн болон төрийн бус байгууллагын санаачлагаар хуримтлагдсан хөрөнгө
- Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын өөрийн хөрөнгө
- Бусад эх үүсвэр

	2021	2022	2023
Зарцуулсан төсөв	104,1 сая	16,2 сая	81.6 сая

## ЗОРИЛТУУД

1. Шинжлэх ухаанч үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, судалгаа ба хөгжлийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах;
2. Үндэсний хэл соёлоо дээдлэх, монгол бичиг сурах хөдөлгөөнийг нийтийн хэмжээнд өрнүүлэх;
3. Хотын соёлыг иргэн бүрт төлөвшүүлэх, иргэншсэн нийгэмд тухайн хүний амьдрах зөв хэвшлийг бий болгож, нийт олны эрх ашигт захирагдан гэгээрэх хандлагыг төлөвшүүлэх;
4. Соёлт хүн төрөлхтний эрхэм зүйл болох ном унших соёл, номтой нөхөрлөх хөдөлгөөнийг нийтэд түгээн дэлгэрүүлэх;
5. Хүүхэд, залуучуудын оюуны чадамжийг хөгжүүлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах;

1. Шинжлэх ухаанч үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, судалгаа ба хөгжлийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах

1. Аймгийн Засаг даргын нэрэмжит “ЭРДЭМТДИЙН ЧУУЛГАН II”, “БҮТЭЭЛЧ ОЮУТАН 2023”, “ДАРХАН ИННОВАЦИ-62”, “ЭРЧИМ ХҮЧ, УУЛ УУРХАЙН САЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ЧИГ ХАНДЛАГА-2023” зэрэг шинжлэх ухаан танин мэдэхүйн сэдвээр 16 төрлийн үйл ажиллагаа, эрдэм шинжилгээний хурал, уралдааныг зохион байгуулж 6 их дээд сургуулийн 500 орчим багш, оюутан судлаачид оролцсон байна.



## 2. Үндэсний хэл соёлоо дээдлэх, монгол бичиг сурах хөдөлгөөнийг нийтийн хэмжээнд өрнүүлэх

2.1. ЕБС-д “Цагаан сар”, “Монгол бахархлын өдрүүд зэрэг, СӨББ-д “Шагайн наадгай”, “Мэндлэх хүндлэх ёс”, зэрэг өв соёлоо дээдлэх нийт 16 төрлийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор нийт **33950** хүүхэд хамрагдав.

2.2, 2.3. 2021-2023 онд Дархан-Уул аймгийн төрийн болон хувийн хэвшлийн нийт **76** байгууллага, хэлтэст үндэсний бичгээр уншиж бичиж сурах сургалт **71**, цахимд монгол бичгээр бичих сургалт **4** удаа зохион байгуулж нийт **75** удаагийн сургалтад **8126** төрийн албан хаагч, иргэд хамрагдав.

2.4. 2023 онд “Үндэсний бичгийн багш нарын онол, заах арга зүйн төвлөрсөн болон бүсчилсэн **3** удаагийн сургалтад давхардсан тоогоор **228** багш хамрагдсан.

2.5. 16-р сургууль, Од цогцолбор, 1-р сургуулиуд “Үндэсний бичгийн танхим” байгууллаа.

2.6. “Үндэсний бичиг манай хамт олны өв соёл” цахим контентийн уралдааныг **3** жил дараалан зохион байгуулж **58** байгууллага оролцон, цахим орчинд **30,000** гаруй эерэг хандлага түгээсэн.



2.7. Соёлын байгууллагууд ЕБС, цэцэрлэгүүдэд **19** боловсролын хөтөлбөрийг **276** удаа зохион байгуулж **5205** хүүхэд багачуудыг хамруулсан.

2.8. Хүүхэд багачуудад монгол бичгийн мэдлэг чадвар эзэмшүүлэх, дэмжин туслах чиглэлээр **5** арга хэмжээг зохион байгуулж **936** уншигч, хүүхэд багачууд хамрагдсан.

2.9. Бийрийн бичлэгийн уралдааныг ЕБ-ын **7** сургуулийн дунд зохион байгуулж **40** сурагч оролцсон.

2.10. Төрийн албан хаагчдад зориулсан Үндэсний бичгийн **7** удаагийн сургалтад давхардсан тоогоор **327** хүн хамрагдсан.

2.11. “**Хос бичигтэн байгууллага**” арга хэмжээний хүрээнд 2023 онд Соёл, урлагийн газар 22, соёлын байгууллагууд тус бүр 20 албан бичиг үйлдэж амжилттай туршсан.

2.12. **2022 онд “Нүүдэлчин” дэлхийн соёлын наадамд** Монгол уран бичлэгийн төрлөөр оролцогч **Ж.Эрхэмсайхан**, Монгол бичгийг байгалийн болон сав шим ертөнцтэй холбон богино хугацаанд сурах арга зүйгээр оролцогч **Ц.Буянхишиг**,

“Шилдэг бүтээлч үйлдвэрлэл”-ийн төрөлд QR код бүхий "Дархан 60" цахим номоор оролцогч **Б.Булганчимэг** нар Шилдэг өвлөн уламжлагчаар тус тус шалгарсан.

**Нийт ЕБС, СӨБ-ийн 6181 хүүхдийг 280 удаагийн үйл ажиллагаанд хамруулсан.**



### 3. Хотын соёлыг иргэн бүрт төлөвшүүлэх, иргэншсэн нийгэмд тухайн хүний амьдрах зөв хэвшлийг бий болгож, нийт олны эрх ашигт захирагдан гэгээрэх хандлагыг төлөвшүүлэх

- Түүх танин мэдэхүйн “Хаадын түүх” хөтөлбөр, Урлагийн боловсрол олгох “Музей дэх уламжлалт хөгжмийн зэмсгүүдийн тухай” хөтөлбөрүүдийг тус тус хэрэгжүүлж байна.
- Музей дэхь түүхэн уламжлалт хөгжмийн зэмсгүүдийг хэн сайн мэдэх вэ, хэрхэн яаж бүтсэн тухай, ардын язгуур урлагийн хөгжмийн зэмсгүүдийн тухай сургалтыг Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран зохион байгуулав.
- Музейн сан хөмрөгт хадгалагдаж буй алтан ургийн 37 хааны зургаар үзэсгэлэн гаргаж "Оюуны зангилаа" боловсролын хөтөлбөрт ЕБ-ын 11,12 дугаар ангийн сурагчдыг хамруулсан.
- **“Хотын соёл надаас эхэлнэ” эсээ бичлэгийн болон богино хэмжээний видео контент бүтээх уралдааныг зохион байгуулж байна. 2023 онд тус уралдаанд ЕБС-ийн 78 сурагч оролцсон.**
- 2022 онд нийт үйлчилгээнээс урлагийн тоглолт 86 удаа 47329 үйлчлүүлэгчид,
- 2023 онд урлагийн тоглолт 161 удаа тоглогдож 82097 үзэгчдэд үйлчилсэн.





#### 4. Соёлт хүн төрөлхтний эрхэм зүйл болох ном унших соёл, номтой нөхөрлөх хөдөлгөөнийг нийтэд түгээн дэлгэрүүлэх

1. Соёл, урлагийн байгууллагууд зохиолч, уншигчийн уулзалтыг нийт **16** удаа зохион байгуулж **2585** хүнийг хамрууллаа.
2. 2023 онд ЕБ-ын 6 сургууль дээр “Ухаарлын толь” уншигчийн клуб ажиллаж 5200 сурагч хамрагдсан байна. Төв номын санд 2400, Хүүхдийн номын ордонд 3200 сурагч уншлагын танхимаар үйлчлүүлж байна.
3. Уншсан номоос эшлэл аван Zmongol. Oyut, Chimee апп ашиглан үндэсний бичгээр бичих аянд **25** сургуулийн дунд болон ахлах ангийн **11600** гаруй сурагч оролцлоо.
4. Хүүхэд багачуудыг соён гэгээрүүлэх, танин мэдэхүйн зарчимд сургах зорилгоор "Хуруун хүүхэлдэйн үлгэр" видео бичлэгийн уралдааныг ЕБС, СӨББ-ийн дунд зохион байгуулж 112 хүүхдийн бүтээлийг цахим орчинд сурталчиллаа.
5. “Миний мэргэжил сайхан” нэвтрүүлгийн 6 дугаарыг цувралаар бэлтгэн **2469** хүнд хүргэсэн.



# “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд”

“Хүүхэд бүр уншигч”, “Илүү их уншъя”, “Номтой Монгол” зэрэг уриатайгаар жилд 2 удаа зохион байгуулдаг болж нийт 156 арга хэмжээг 219 удаа зохион байгуулж 37 996 иргэдийг хамруулсан байна.



“Алтан үсгийн баяр” үндэсний бичгийн олимпиадыг 21 дэх жилдээ зохион байгуулж байна. 9 ангилалд 688 сурагч, 43 иргэн, 68 багш оролцлоо.



## 5. Хүүхэд, залуучуудын оюуны чадамжийг хөгжүүлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах

ЕБ-ын 25 сургуульд сэтгэн бодох чадвар, спорт, үндэсний бичгийн нийт 29 дугуйланд 4724 гаруй сурагчид хичээллэж байна. ЕБ-ын 3 сургуульд Мэтгэлцээний клуб хичээллэж 42 сурагч хамрагдаж байна. Оюуны спорт, шатар, 100 буудалт даамны 5 клубт 145 тамирчин иргэд хамрагдаж байна.

Монголын оюун ухааны академийн Дархан салбарт 153 сурагч суралцаж байгаагаас 2 суралцагч Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн:

- Дэлхийн рекордыг шинэчлэн тогтоосон - 1
- Өсвөрийн дэлхийн аварга - 1
- Спорт өрөлт хүрэл медаль - 3

Азийн аварга шалгаруулах тэмцээн:

- Хүрэл медаль / Багийн төрөл / тус тус хүртсэн.





- Бүтээлч болон шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх, гэр бүлийн хүрээнд хүүхдийг хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах хүрээнд “Миний гэр бүл” өдөрлөг зохион байгуулсан.

-Гэр бүлээрээ ном унших чиг хандлагад төлөвшүүлэх зорилгоор гэрээр ном олгох үйлчилгээг тогтмол зохион байгуулж, 10,508 уншигч, 108,756 ирэгсдэд, 122,845 боть ном олгож үйлчилсэн.

## Соёлын байгууллагуудын үзвэр, үйлчилгээний статистик тоо:

№	Соёлын байгууллагууд	2022 он	2023 он
1	Залуучууд театр	221	377
2	Музей	137	273
3	Төв номын сан	71726	77944
4	Хүүхдийн номын сан	62015	78858

## Соёлын байгууллагуудын үйлчлүүлэгчдийн статистик тоо:

№	Соёлын байгууллагууд	2022 он	2023 он
1	Залуучууд театр	77884	149777
2	Музей	14087	28102
3	Төв номын сан	86136	88021
4	Хүүхдийн номын сан	58859	69451

# ҮНЭЛГЭЭ


<b>2021</b>	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ:							
	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5
		84.82%	5	90	90	72.5	87.75	83.33
	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ХШҮнэлгээ)		Нэгдсэн үнэлгээ					
		83.68% буюу 4.18 оноо						

<b>2022</b>	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ:							
	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5
	Гүйцэтгэл	88.50%	5	90.0	90.0	84.0	90.0	75.0
	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ХШҮнэлгээ)		Нэгдсэн үнэлгээ					
		88.50 буюу 4.43 оноо						

<b>2023</b>	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ:							
	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5
	Гүйцэтгэл	90.00%	5	83.33	100	80.0	100	82.5
	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ХШҮнэлгээ)		Нэгдсэн үнэлгээ					
		90.0 буюу 4.5 оноо						



# ҮНЭЛГЭЭ





# ДҮГНЭЛТ

## Ололттой тал:

Дархан-Уул аймгийн иргэд олон нийт, хүүхэд залуусыг хөгжүүлэх, оюунлаг бүтээлч байхыг уриалсан олон талт ажлуудыг төлөвлөж зохион байгуулснаар соёлын салбарын үйлчилгээ, үйлчлүүлэгчид нэмэгдсэн.

“Үндэсний хэл соёлоо дээдлэх, Хос бичигтэн байгууллага арга хэмжээний хүрээнд соёлын байгууллагууд монгол бичиг сурах ажлыг амжилттай зохион байгуулсан.

2025 оноос төрийн албан хэргийг крилл болон монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

## Дутагдалтай тал:

-Салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах.

-Соёлын олон талт үйл ажиллагааг зохион байгуулахад зардал, санхүүжилт дутмаг, төсөвт тусгагдаагүй.

-Оролцоо хангалтгүй.

-Төлөвлөгөө уялдаа холбоогүй, гэнэтийн ажлууд төлөвлөгддөг.